

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Зүүнбаян-Улаан сумын ИТХ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: **ӨВА-2022/64/НА-СТА-ТШЗ**

<p>Цахим хуудас: www.audit.mn Арвайхээр 2022 он</p>	<p>Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: О.Батжаргал Утас: 70323253 Цахим хаяг: BatjargalO@audit.gov.mn Аудитын менежер: Д.Гансүх Утас: 70323833 Цахим хаяг: GansukhD@audit.gov.com Аудитор: Р.Энхзул Утас: 70323833 Цахим хаяг: EnkhzulR@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Аудитын тайлан
- 3.1 Ерөнхий зүйл
- 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....
- 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
- 3.4 Материаллаг байдал.....
- 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга
- 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв
- 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг
- 3.8 Аудитын гол асуудал.....
- 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....
- 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
- 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал
4. Аудитын илрүүлэлт.....
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал

1. Аудитын дүгнэлт



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,
Утас/Факс: (976) 7032 3253,
Цахим шуудан: uvurkhangai@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2022.04.25 № 201
танай _____-ны № _____-т

ЗҮҮНБАЯН-УЛААН СУМЫН ИТХ-ЫН
НЭРИЙН БИЧГИЙН ДАРГА
Ц.ОДОНЖАРГАЛ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Зүүнбаян-Улаан сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ. Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Зүүнбаян-Улаан сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тус байгууллага нь бараа материалын орлого, зарлагыг бөөн дүнгээр бүртгэснээр хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт хэрэгжихгүй байх эрсдэлтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн "5.1.5.хэмжигдэхүйц байх, 14.3.3.дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх, 14.4.1.аж ахуйн бүх ажил, гүйлгээ" гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн Эрх ба үүрэг, Толилуулга гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

015030542

D:\Audiitiin gazar\baiguullagiin dotood barimt\A4


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

The image shows a rectangular official stamp with Mongolian text. Overlaid on the stamp is a handwritten signature in black ink. The signature appears to be 'О.Батжаргал'.

О.БАТЖАРГАЛ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл /төгрөгөөр/

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	29,500.00	929,500.00
33	АВЛАГА	-	100,000.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	100,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	29,500.00	829,500.00
354	Хангамжийн материал	29,500.00	29,500.00
35410	Бичиг хэргийн материал	-	800,000.00
35470	Бусад хангамжийн материал	-	800,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	6,858,386.08	4,447,719.13
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,858,386.08	4,447,719.13
392	Биет хөрөнгө	35,000,000.00	35,000,000.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	(34,734,476.98)	(35,000,000.00)
39204	Хуримтлагдсан элэгдэл	13,048,900.00	12,698,900.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	(12,028,899.92)	(11,914,900.08)
39206	Хуримтлагдсан элэгдэл	17,794,000.00	17,794,000.00
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	(12,221,480.75)	(14,130,280.79)
39208	Хуримтлагдсан элэгдэл	82,135.00	82,135.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	(81,791.27)	(82,135.00)
39215	Хуримтлагдсан элэгдэл	50,000.00	50,000.00
39301	Програм хангамж	(50,000.00)	(50,000.00)
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	6,887,886.08	5,377,219.13
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,887,886.08	5,377,219.13
51	Засгийн газрын хувь оролцоо	6,887,886.08	5,377,219.13
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	15,713,500.00	15,713,500.00
51101	Өмч: - төрийн	(9,260,086.92)	(10,770,753.87)
512	Хуримтлагдсан үр дүн	(9,260,086.92)	(9,260,086.92)
51210	Өмнөх үеийн үр дүн	-	(1,510,666.95)
51220	Тайлант үеийн үр дүн	434,473.00	434,473.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	-	-
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	6,887,886.08	5,377,219.13

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	85,538,300.00	85,585,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	85,538,300.00	85,585,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	85,538,300.00	85,585,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	85,538,300.00	85,585,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	91,368,857.76	87,096,066.95
21	УРСГАЛ ЗАРДАЛ	91,368,857.76	87,096,066.95
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	89,083,970.91	85,693,877.94
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	69,024,346.15	63,883,752.07
210101	Үндсэн цалин	63,532,546.15	62,740,652.07
210104	Урамшуулал	5,491,800.00	1,143,100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,911,064.00	8,235,458.92
210201	Тэтгэврийн даатгал	2,676,326.00	5,737,826.08
210202	Тэтгэмжийн даатгал	308,685.00	638,991.07
210203	ҮОМШӨ-ний даатгал	247,187.00	511,192.86

Зүүнбаян-Улаан сумын ИТХ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210204	Ажилгүйдлийн даатгал	61,497.00	122,495.35
210205	Эрүүл мэндийн даатгал	617,369.00	1,224,953.56
2104	Хангамж, бараа материалын зардал	4,206,851.00	4,500,400.00
210401	Бичиг хэрэг	751,300.00	728,700.00
210402	Тээвэр, шатахуун	3,285,551.00	3,271,700.00
210404	Ном, хэвлэл	170,000.00	500,000.00
2105	Нормативт зардал	-	48,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	48,500.00
2107	Томилолт, зочны зардал	593,000.00	970,000.00
210702	Дотоод албан томилолт	593,000.00	970,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	136,525.00	157,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	136,525.00	135,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	22,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,212,184.76	7,898,366.95
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,150,000.00	3,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	998,000.00	1,987,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	6,064,184.76	2,910,666.95
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,284,886.85	1,402,189.01
2132	Бусад урсгал шилжүүлэг	290,000.00	700,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	290,000.00	700,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,994,886.85	702,189.01
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,994,886.85	702,189.01
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(5,830,557.76)</u>	<u>(1,510,666.95)</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(5,830,557.76)</u>	<u>(1,510,666.95)</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	15,713,500.00	434,473.00	-9,260,086.92	0.00	6,887,886.08
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	15,713,500.00	434,473.00	-9,260,086.92	0.00	6,887,886.08
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн					0.00
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	15,713,500.00	434,473.00	-9,260,086.92	0.00	6,887,886.08
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	15,713,500.00	434,473.00	-9,260,086.92	0.00	6,887,886.08
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	15,713,500.00	434,473.00	-9,260,086.92	0.00	6,887,886.08
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-1,510,666.95	0.00	-1,510,666.95
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	15,713,500.00	434,473.00	-10,770,763.87	0.00	5,377,219.13

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>85,538,300.00</u>	<u>85,585,400.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>85,538,300.00</u>	<u>85,585,400.00</u>
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	85,538,300.00	85,585,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	85,538,300.00	85,585,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>85,538,300.00</u>	<u>85,085,400.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>85,538,300.00</u>	<u>85,085,400.00</u>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	<u>83,253,413.15</u>	<u>83,683,210.99</u>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	64,837,108.00	63,983,752.07
210101	Үндсэн цалин	54,403,488.00	53,661,652.07

Зүүнбаян-Улаан сумын ИТХ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210104	Урамшуулал	10,433,620.00	10,322,100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,098,302.15	8,235,458.92
210201	Тэтгэврийн даатгал	5,523,953.39	5,737,826.08
210202	Тэтгэмжийн даатгал	648,372.69	638,991.07
210203	ҮОМШӨ-ний даатгал	518,937.75	511,192.86
210204	Ажилгүйдлийн даатгал	127,693.94	122,495.35
210205	Эрүүл мэндийн даатгал	1,279,344.38	1,224,953.56
2104	Хангамж, бараа материалын зардал	4,440,478.00	4,500,400.00
210401	Бичиг хэрэг	751,300.00	728,700.00
210402	Тээвэр, шатахуун	3,519,178.00	3,271,700.00
210404	Ном, хэвлэл	170,000.00	500,000.00
2105	Нормативт зардал	-	48,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	48,500.00
2107	Томилолт, зочны зардал	593,000.00	970,000.00
210702	Дотоод албан томилолт	593,000.00	970,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	136,525.00	157,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	136,525.00	135,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	22,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,148,000.00	5,787,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,150,000.00	3,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	998,000.00	2,787,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,284,886.85	1,402,189.01
2132	Бусад урсгал шилжүүлэг	290,000.00	700,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	290,000.00	700,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,994,886.85	702,189.01
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,994,886.85	702,189.01
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	500,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	500,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	500,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	500,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	500,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	(500,000.00)

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	85,585,400.00	84,883,210.99
21	УРСГАЛ ЗАРДАЛ	85,585,400.00	84,883,210.99
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	84,885,400.00	84,183,210.99
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	63,986,400.00	63,983,752.07
210101	Үндсэн цалин	53,546,400.00	53,543,752.07
210104	Урамшуулал	10,440,000.00	10,440,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,638,200.00	8,235,458.92
210201	Тэтгэврийн даатгал	6,078,700.00	5,737,826.08
210202	Тэтгэмжийн даатгал	639,900.00	638,991.07
210203	ҮОМШӨ-ний даатгал	511,900.00	511,192.86
210204	Ажилгүйдлийн даатгал	128,000.00	122,495.35
210205	Эрүүл мэндийн даатгал	1,279,700.00	1,224,953.56
2104	Хангамж, бараа материалын зардал	4,780,000.00	4,500,400.00
210401	Бичиг хэрэг	728,700.00	728,700.00
210402	Тээвэр, шатахуун	3,551,300.00	3,271,700.00
210404	Ном, хэвлэл	500,000.00	500,000.00
2105	Нормативт зардал	48,500.00	48,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	48,500.00	48,500.00
2107	Томилолт, зочны зардал	970,000.00	970,000.00
210702	Дотоод албан томилолт	970,000.00	970,000.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	174,600.00	157,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	145,500.00	135,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	29,100.00	22,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,287,700.00	6,287,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,000,000.00	3,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,287,700.00	3,287,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	700,000.00	700,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	700,000.00	700,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	700,000.00	700,000.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Нэмэлт төсвийн гүйцэтгэл байхгүй

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Зүүнбаян-Улаан сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд зөвлөмж өгөгдөөгүй болно

Аудитыг Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газрын аудитор Р.Энхзул гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Гансүх, газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор О.Батжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Зүүнбаян-Улаан сумын ИТХ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймгийн Төрийн аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 01 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Зүүнбаян-Улаан сумын ИТХ нь нутаг дэвсгэрийн эдийн засаг нийгмийн асуудлыг хуулийн хүрээнд хариуцаж, бие даан шийдвэрлэх чиг үүрэг бүхий байгууллага юм.

Тайлант хугацаанд тус байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллагат дотоод хяналт хэрэгжихгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Зүүнбаян-Улаан сумын ИТХ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 88496.1 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 885.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80.0 хувь буюу 708.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Санхүүгийн тайланд үндсэн хөрөнгө болон бараа материалын тодруулгыг бэлтгэжээ:

- Үндсэн хөрөнгөд тайлант онд 350.0 мянган төгрөгөөр буурсан нь худалдан авсан 500.0 мянган төгрөгийн камераар нэмэгдэж, 850.0 мянган төгрөгийн зөөврийн компьютерыг акталсантай холбоотой байна.
- Бараа материал оны эхнээс 800.0 мянган төгрөгөөр өссөн нь худалдан авсан бусад хангамжийн материал нэмэгдсэнтэй холбоотой байн

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төслийг хуулийн хугацаанд бэлтгэж, нэгтгүүлж ирсэн байна. 2021 оны төсвийн төсөлд нийт зардлыг 81211.0 мянган төгрөгөөр төлөвлөсөн ба санхүүжилт 85585.4 мянган төгрөгөөр батлагджээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайланд оны төсөв 85585.4 мянган төгрөгөөр батлагдаж, 85585.4 мянган төгрөгийн санхүүжилт ирсэн ба 702.2 мянган төгрөгийг төвлөрүүлж, гүйцэтгэл 84883.2 мянган төгрөг байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилт орж ирээгүй байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

3.8 Аудитын гол асуудал

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдлыг аудитын гол асуудлыг тодорхойлоход харгалзаж үзсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим, сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 4 горим сорил гүйцэтгэхэд 6187.7 мянган төгрөгийн бараа материалын орлого, зарлагыг бөөн дүнгээр бүртгэсэн зөрчил илэрлээ. Цалингийн урьдчилгаа болох 100.0 мянган төгрөгийг авлагат тусгаагүй, шинээр худалдан авсан 500.0 мянган төгрөгийн камерыг үндсэн хөрөнгөд бүртгээгүй, худалдан авсан 800.0 мянган төгрөгийг самбарыг шууд зарлагадсан зөрчлүүдийг аудитын явцад залруулав.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Зүүнбаян-Улаан сумын ИТХ нь шилэн дансны цахим хуудсанд нийт 149 мэдээлэл байршуулахаас 125 мэдээллийг хугацаанд нь, хугацаа болоогүй 1 мэдээлэл, 23 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол зэрэг бусад хууль тогтоомжийн хүрээнд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шалгасан зүйлсийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэсэн болно.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар "Шилэн дансны хуулийн хэрэгжилт болон тээвэр шатахууны зарцуулалтын тайланг батлагдсан маягтаар гаргаагүй, мөн жолоочийн тооцоог бодож акт үйлдэж баталгаажуулаагүй" зөрчилд албан шаардлага өгөгдсөн бөгөөд албан шаардлагыг хэрэгжүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал хандуулах асуудал байхгүй.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 7587.7 мянган төгрөгийн алдаа илэрсэн.

4.1 Залруулга

Цалингийн урьдчилгаа болох 100.0 мянган төгрөгийг авлагат тусгаагүй, шинээр худалдан авсан 500.0 мянган төгрөгийн камерыг үндсэн хөрөнгөд бүртгээгүй, худалдан авсан 800.0 мянган төгрөгийг самбарыг шууд зарлагдсан зөрчлүүдийг аудитын явцад залруулав.

4.2 Төлбөрийн акт

Акт тавигдаагүй.

4.3 Албан шаардлага

Бараа материалын 6187.7 мянган төгрөгийн орлого, зарлагыг бөөн дүнгээр бүртгэсэн зөрчилд албан шаардлага өгсөн.

4.4 Зөвлөмж

Зөвлөмж байхгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Зүүнбаян-Улаан сумын ИТХ	4	7587.7	3	1400.0			1	6187.7		

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН: АУДИТОР



О.БАТЖАРГАЛ

Д.ГАНСҮХ

Р.ЭНХЗУЛ